



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/18

Шивээговь сум

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2, Засгийн газрын 2018 оны 04 дүгээр тогтоол “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомж, батлагдсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон залуучуудын оролцоог дэмжих арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хагас, бүтэн жилээр сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлд тайлагнахыг зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Н.Амаржаргал)-д үүрэг болгосугай.


3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/76 дугаар “Залуучуудын салбар зөвлөл байгуулах тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2025 оны 4-р
сарын 24-ны өдрийн 118 дугаар
захирамжийн хавсралт



ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Тэргүүн:	Ч.Сугармаа (Засаг дарга)
Дэд тэргүүн:	Л.Бадамханд (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Н.Амаржаргал (Мэдээ мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан)
Гишүүд:	Д.Маналмаа (2 дугаар багийн Засаг дарга) Б.Алтансүх (Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн) С.Дэлгэрэх (Шивээ-Овоо хувьцаат компанийн Цахим мэдээллийн инженер) А.Батжаргал (Цагдаагийн хэсгийн мөрдөгч) О.Эрдэнэбаяр (Шагайн холбооны гишүүн) Д.Сансармаа (Эрүүл мэндийн төвийн Их эмч) Ч.Түмэн-Очир (3 дугаар сургуулийн Нийгмийн ухааны багш) Б.Даариймаа (3 дугаар сургуулийн Монгол хэл бичиг уран зохиолын багш)

Т.Бумдорж

(3 дугаар сургуулийн Биеийн тамирын
багш)

А.Рэгзэдмаа

(3 дугаар цэцэрлэгийн багш)

М.Оюун-Эрдэнэ

(21 дүгээр Зөрлөгийн дарга)

Э.Ариунгэрэл

(Хувиараа бизнес эрхлэгч)

Б.Лхамсүрэн

(Хувиараа бизнес эрхлэгч)

Р.Содхүү

(Уяачдын холбооны гишүүн)

Б.Цэрэнчимэд

(3 дугаар цэцэрлэгийн багш)